



DEFENSE RESEARCH  
INSTITUTE OF MONGOLIA

## Journal of Security and Defense Studies

Journal homepage:  
[https://mids.gov.mn/category/ayulgui\\_baidal-2/](https://mids.gov.mn/category/ayulgui_baidal-2/)

ISSN: 2220-9115, E-ISSN: 2708-1230



Research Article

DOI: <https://doi.org/10.65816/jsds.2026.01.011>

# Changes in China's Defense Sector

Chimedsuren Sereenen<sup>1</sup>, Ganbaatar Sugar<sup>2</sup>

<sup>1</sup>Major, Researcher, Security studies center, Defense Research Institute of Mongolia,  
E-mail address: [sereenen@mids.gov.mn](mailto:sereenen@mids.gov.mn), ORCID: 0009-0000-3134-7523

<sup>2</sup>Researcher, Security studies center, Defense Research Institute of Mongolia,  
E-mail address: [sugar@mids.gov.mn](mailto:sugar@mids.gov.mn), ORCID: 0009-0008-9104-5445

Received: 13 February 2026  
Accepted: 25 March 2026

Revised: 15 March 2026  
Published online: 30 March 2026



### ABSTRACT

To align with the rapidly evolving global politico-military landscape, the Chinese leadership is pursuing intensive and continuous military reforms. These efforts aim to establish a compact, highly proficient, and modern professional military that meets the standards of the world's leading armed forces. Within this framework, significant organizational restructurings have been implemented to address the exigencies of rapid technological evolution. Accordingly, this article examines the major transformations within China's military reform program in recent years, their subsequent outcomes, and their potential implications for regional stability.

**Keywords:** politico-military, modernization program, regional stability, professional army.

## Хятадын батлан хамгаалах салбарт гарсан өөрчлөлт

Чимэдсүрэн Сэрээнэн<sup>1</sup>, Ганбаатар Сугар<sup>2</sup>

<sup>1</sup>Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Аюулгүй байдал судлалын төвийн эрдэм шинжилгээний ажилтан, хошууч, [sereenen@mids.gov.mn](mailto:sereenen@mids.gov.mn), ORCID: 0009-0000-3134-7523

<sup>2</sup>Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Аюулгүй байдал судлалын төвийн эрдэм шинжилгээний ажилтан, [sugar@mids.gov.mn](mailto:sugar@mids.gov.mn), ORCID: 0009-0008-9104-5445

### ХУРААНГУЙ

Дэлхийн нийтийн цэрэг-улс төрийн нөхцөл байдлын хурдтай хувьсан өөрчлөгдөж буй үйл явцтай уялдуулж, дэлхийн хүчирхэг зэвсэгт хүчин бүхий улс орнуудын жишигт хүрсэн, цомхон чадварлаг, орчин үеийн мэргэжлийн армитай болох зорилтоо хүрэхийн тулд Хятадын удирдлагууд цэргийн шинэчлэлийг тасралтгүй, эрчимтэй үргэлжлүүлэн явуулж байна.

Энэ хүрээнд орчин үеийн технологийн хурдтай хувьсаас үүдсэн хэрэгцээ шаардлагатай холбоотойгоор шинэчлэлийн явцад зохион байгуулалтын зарим өөрчлөлтүүд хийгдсэн.

Иймээс энэ өгүүлэлд сүүлийн жилүүдэд Хятадын цэргийн шинэчлэлийн хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн томоохон өөрчлөлт болон түүний үр дүн, бүс нутгийн тогтвортой байдалд үзүүлж болох нөлөөллийн талаар судалсан болно.

**Түлхүүр үгс:** цэрэг-улс төр, шинэчлэлийн хөтөлбөр, бүс нутгийн тогтвортой байдал, мэргэжлийн арми.

## Оршил

Тус улс батлан хамгаалах бодлогоо шинэчлэх ажлын хүрээнд 2019 онд “Шинэ эриний Хятадын үндэсний батлан хамгаалах цагаан ном (*China 2019*)”-ыг батлан гаргасан. Энэ удаа АНУ тус улсыг стратегийн гол өрсөлдөгч хэмээн зарласныг хүлээж авсан төдийгүй үүний хариуд өсөн нэмэгдэж буй Хятадын цэргийн хүч АНУ-тай өрсөлдөхөд бэлэн байна гэж зарласнаараа онцлог байлаа. БНХАУ бүс нутгийн энх тайван, тогтвортой байдлын хэтийн төлөвийг тодорхойгүй болгож байгаа хүчнээр АНУ-ыг нэрлэж, үүнийгээ Хятадын эсрэг цэргийн эвсэл холбоог бэхжүүлж, бүс нутагт байрлуулсан цэргийн хүчээ зузаатган, тухайлбал БНСУ-д Агаарын довтолгооноос хамгаалах (ТНААД) систем байршуулсан зэргээр тайлбарласан.

Хятадын үндэсний стратеги нь 2049 онд тохиох БНХАУ байгуулагдсаны 100 жилийн ойн босгон дээр “Хятад үндэстний агуу сэргэн мандалт”-ыг хэрэгжүүлэх зорилтдоо хүрэхийн сацуу “үйл явдлыг шинэ түвшинд гаргахын тулд бусдад нөлөөлөх, өөртөө татах, хүч чадлаа” нэмэгдүүлж, улс орныхоо тусгаар тогтнол, аюулгүй байдал, хөгжлийн ашиг сонирхлыг “тулаанд ялж”, “шийдвэртэй хамгаалж” чадах “дэлхийн жишиг”-т хүрсэн Зэвсэгт хүчийг бий болгох зорилготой юм. Хятад улс нэгд, Хятадын Коммунист Нам (ХКН)-ын хяналт, хоёрт Эдийн засгийн хөгжлийг дэмжих, гуравт, Нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал гэсэн гурван “үндсэн ашиг сонирхол”-ыг Хятадын үндэсний сэргэн мандалтын гол асуудал гэж тодорхойлсон.

Хятад улс цэргийн хүчээ бэхжүүлэн, шинэчлэл хийж буйгаа цэвэр өөрийгөө хамгаалах зорилготой хэмээн тайлбарлахын зэрэгцээ өөрийн энх тайванч бодлогын талаар байнга сурталчилж, Өмнөд болон Зүүн Хятадын тэнгист явуулж буй цэргийн үйл ажиллагаагаа ч мөн энхийн төлөө хүчин чармайлт гэж нотолсоор байна.

БНХАУ-ын удирдлага гол аюул заналд Тайвань, Төвд, Туркестаны салан тусгаарлах хөдөлгөөн, хөрш орнуудын хооронд үүссэн газар нутгийн маргаан, үндэсний аюулгүй байдлын эрх ашгийг үл тоомсорлож буй АНУ зэрэг гадны хүчин зүйлсийг тооцсон байна (*Battulga 2025*).

2015 оноос эхэлсэн Хятадын цэргийн шинэчлэл дараах 3 үе шаттай явагдаж байна. Үүнд:

### 1. 2015–2020 он. Шинэчлэлийн I үе.

- Цэргийн төв зөвлөл, удирдлагын түвшний зохион байгуулалтын өөрчлөлт;
- Төрлийн цэргийн зохион байгуулалтын өөрчлөлт (байлдааны тойрог, армийн хэмжээний зохион байгуулалтын өөрчлөлт);
- Орон тооны цомхотгол.

2. 2020-2030 он. Шинэчлэлийн II үе. (2027 онд ХАЧА-ийн 100 жилийн ой тохиож байна)

Энэ шатанд ХАЧА-д мэдээлэлжсэн, хиймэл оюуныг нэгтгэх ажлыг “хурдасгах”, тухайлбал:

- Хиймэл оюун (AI), машин сургалт, квант тооцоолол зэрэг технологийг цэргийн бүх салбарт нэвтрүүлэх ажлыг түргэсгэх;
- ХАЧА-ийн төрөл бүрийн операцыг бүх талбарт явуулах нэгдсэн ажиллагааны

чадварыг нэмэгдүүлэх;

- Кибер, сансар огторгуй, мэдээллийн орон зай зэрэг шинэ домэйн хүчний хөгжил, ашиглалтыг хурдасгах зэрэг арга хэмжээг хэрэгжүүлнэ.

**3. 2030-2045 он. Шинэчлэлийн II үе.** Цэргийн шинэчлэлийг дуусгах:

- Хиймэл оюун(AI), өндөр технологи, квант тооцоолол зэрэг технологийн аргуудыг удирдлага, харилцаа холбоо, зэвсэглэлийн системд нэвтрүүлж, бүрэн шинэчлэгдсэн буюу «ухаалагжсан, оюунжсан» цэрэг армитай болох;
- Хятад улсын өсөн нэмэгдэж буй үндэсний ашиг сонирхол, тэр дундаа хилийн чанад дахь худалдаа, аюулгүй байдлаа бэхжүүлэхийн тулд тодорхой бүс нутгуудад бүх талбарт (хуурай газар, далай, агаар, кибер, сансар) хүч хэрэгслээ байршуулах чадвартай болох;
- Хиймэл оюун (AI), квант тооцоолол, их өгөгдөл зэрэг өндөр технологиудыг цэргийн шийдвэр гаргах түвшинд болон бусад үйл ажиллагаанд ашигладаг болох;
- Үндэсний батлан хамгаалах, аюулгүй байдлыг хангахад цэргийн хүч чадлаас давсан цогц арга барил шаардлагатай байгаа учраас иргэний оролцоо, шинжлэх ухаан, технологийн дэвшил, бүс нутгийн хамтын ажиллагааг тогтвортой аюулгүй байдлын тогтолцооны чухал бүрэлдэхүүн хэсэг болгон нэгтгэхэд чиглүүлэх;
- Эцэст нь 2049 (БНХАУ байгуулагдсаны 100 жил) он гэхэд Хятад улс дэлхийн хамгийн хүчирхэг армитай болсон байна.

Өнөө үе буюу шинэчлэлийн хоёр дахь үе шатанд (2020–2030) орчин үеийн шинжлэх ухаан технологийн хөгжлийн хурдтай хувьслаас үүдэлтэй батлан хамгаалах салбарын хэрэгцээ шаардлагад нийцүүлж армид дахин зохион байгуулалтын зарим өөрчлөлт, зэвсэглэл техникийг шинэчлэн сайжруулахын тулд ХАЧА-д мэдээлэлжсэн, хиймэл оюуныг нэгтгэх ажлыг “хурдасгах” ажил явж байна.

Шинэчлэлийн хүрээнд батлан хамгаалах бодлого, цэргийн стратегид дараах өөрчлөлтүүд хийсэн байна. Үүнд:

- 2022 оны 10 дугаар сард болсон Хятадын Коммунист Намын Төв Хорооны бүгд хурлын нээлт дээр Ши Жиньпин хэлсэн үгэндээ, Зэвсэгт хүчнийг хөгжлийг хурдасгаж, 2027 он гэхэд шинэчлэлийн чухал үе шатыг амжилттай хэрэгжүүлэн Тайванийг нэгтгэх, газар нутгийн маргаан, усан хилийн асуудлыг өөрт ашигтайгаар шийдэх гэжээ.
- 2022 онд ХАЧА “MultiDomain Precision Warfare (MDPW)” нэртэй цэргийн ажиллагааны шинэ үзэл баримтлалыг дэвшүүлсэн нь АНУ-ын үйл ажиллагааны систем дэх эмзэг байдлыг илрүүлж, өндөр нарийвчлалтай цохилт өгөх зорилготой.
- ХКН 2022 оны эхээр Цэрэг-иргэний нэгдэл (MCF)7 нэртэй стратегийг дэвшүүлсэн. Энэ нь иргэний салбар дахь шинжлэх ухаан, үйлдвэрлэлийн ололт амжилтыг цэргийн шинэчлэлтэй нэгтгэж батлан хамгаалах чадавхыг нэмэгдүүлэх зорилготой.
- Хятад улс 2023 оны 3 дугаар сард нөөцийн тухай хуулийг баталж, 2024 оны дунд үеэс эхлэн нөөцийн бүрэлдэхүүнийг байнгын ангиудтай нэгтгэх “нэмэлт”

боловсон хүчин болгон сургаж эхэлсэн. Энэ нь иргэний салбарын өндөр хөгжсөн технологийг цэргийн салбарт шууд нэвтрүүлж ашиглах зорилготой “Иргэн-Цэргийн нэгдмэл стратеги” “军民融合战略” “Military-Civil Fusion” хэмээх бодлогын нэг хэсэгтэй уялдан холбогдож байгаа юм.

- 2024 онд Цэргийн төв зөвлөлийн материал техникийн ерөнхий газар, Хятадын төмөр замын корпораци хамтран шинэ зууны цэргийн төмөр замын тээврийн үйлчилгээний салбарт цэрэг-иргэний хамтын ажиллагааны тухай удирдамжийг баталснаар хятадын шинэ зууны цэрэг-иргэний харилцааны уг чиглэлийн зохицуулалтын эхлэл болсон.

### Бүтэц, зохион байгуулалт:

2024 оны 4 дүгээр сарын 19-ний Цэргийн Төв Зөвлөлийн шийдвэрээр цэргийн шинэчлэлд зохион байгуулалтын дахин өөрчлөлт явуулж Стратегийн дэмжлэгийн хүчнийг таган буулгаж Мэдээллийн дэмжлэг үзүүлэх хүчин, Цэргийн сансрын хүчин, Кибер орон зайн хүчнийг шинээр байгуулсан (金久 2024).

**1. Төсөв:** Хятад Улс 2027 онд тохиох АЧА-ийн 100 жилийн ойг угтаж цэргийн шинэчлэлийн хүрээнд юуны өмнө батлан хамгаалах төсвийг тогтвортой өсөлтийн хэлбэрээр хадгалах бодлого баримталж байна.

2026 оны Хятадын батлан хамгаалах төсөв хараахан батлагдаагүй байгаа. Тус улс жил бүрийн 3 дугаар сард болдог Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Их Хурлаар батлан хамгаалах төсвөө баталж албан ёсоор зарладаг.

Харин 2025 онд тус улсын батлан хамгаалах төсөв 1.784.665 их наяд юуниар батлагдсаныг 2024 онтой харьцуулахад 7.2%-иар өссөн үзүүлэлттэй (雲程萬里通財 2026).

### Хүснэгт 1. Батлан хамгаалах төсвийн сүүлийн 5 жилийн үзүүлэлтийг дараах байдлаар танилцуулбал

| Он   | Төсвийн дүн (юань) | Харьцуулсан хувь |
|------|--------------------|------------------|
| 2025 | 1.784.665 их наяд  | 7.2 %            |
| 2024 | 1.665.208 их наяд  | 7.2 %            |
| 2023 | 1.553.7 их наяд    | 7.2 %            |
| 2022 | 1.450.45 их наяд   | 7.1 %            |
| 2021 | 1.355.343 их наяд  | 6.8 %            |

Цэргийн төсвийн дийлэнх хувийг дараах чиглэлд зарцуулж байна.

- Шинэ төрлийн байлдааны ажиллагааг уламжлалт байлдааны ажиллагааны хүч хэрэгсэлтэй хослуулан хөгжүүлэх, төрлийн бүтцэд дахин зохион байгуулалтын өөрчлөлт хийхэд;
- Тагнуул, урьдчилан сэрэмжлүүлэх арга хэмжээ авах, аюулгүй байдлыг цогц систем болон чадавхыг хөгжүүлэхэд;
- Цэргийн их дээд сургуулиудын сургалтын агуулгыг гүнзгийрүүлэх, цэргийн боловсон хүчин бэлтгэх шинэ системийг бэхжүүлэхэд;
- Батлан хамгаалах болон цэргийн шинэчлэлийг үргэлжлүүлэн гүнзгийрүүлж, хүний нөөцийн бодлого, тогтолцоог боловсронгуй болгох, анги салбарын түвшний сургалт, байлдааны бэлэн байдал, ажлын болон ахуйн нөхцөлийг

сайжруулахад.

Цэргийн шинэчлэлийн хоёр дахь үе шатны хугацаанд хэрэгжүүлэхээр зорьсон зэвсэглэл техникийг сайжруулах ажлын хүрээнд Хятадын хөрш зэргэлдээ улс болон бүс нутгийн цэрэг-улс төрийн цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалж Агаарын цэрэг, Тэнгисийн цэргийн хүчний зэвсэг, техникийг шинэчлэн сайжруулах, системийн өөрчлөлт хийхэд түлхүү анхаарч байгаагийн сацуу уламжлал болсон өндөр өртөгтэй зэвсэглэлийн тоог багасгаж, оронд нь сүлжээнд суурилсан, мэдрэгчээр ажилдаг, бие даан шийдвэр гаргадаг зэвсэглэл рүү шилжиж байгаа ба үүнд батлагдсан төсвийн зонхилох хувийг зарцуулсан байна. Тухайлбал;

Тус улс “оюунжсан” (智能化) буюу хиймэл оюунд суурилсан бие даан шийдвэр гаргах зэвсэглэлийг хөгжүүлж эхлээд байна.

Байлдааны орон зай бүрд хүнгүй (unmanned) системийг ашиглахыг зорьж байна. Үүнд:

- хуурай газарт «робот-нохой»,
- агаарын орон зайд дрон,
- усан доор жолоочгүй хэрэгсэл,
- сүргийн довтолгооны зэвсгүүд гэх мэт төрлүүд багтана.

*Даширамд дурдахад*, Хятадын цэргийн аж үйлдвэрүүд данганц буудлагын зэвсэг, танк, байлдааны машин, хуягт техник гэх мэт цэргийн зориулалттай бүтээгдэхүүн үйлдвэрлэхээс гадна улс ардын аж ахуй, улс орны бүтээн байгуулалтын хэрэгцээ шаардлагад нийцсэн бусад төрлийн бүтээгдэхүүнүүдийг үйлдвэрлэж улсын эдийн засагт тодорхой хувь нэмэр оруулж байна.

**Агаарын цэргийн хүчин:** Хятадын ардын чөлөөлөх арми (ХАЧА) анх удаа зургаа дахь үеийн сөнөөгч онгоцны туршилтын нислэг үйлдэж, радарт үл үзэгдэх 2 нэгж онгоц (Жянь-6/J-36/, Жянь-50/J-50/) туршсан. Мөн нисэх онгоц тээгч хөлөг онгоцонд зориулагдсан 5 дахь үеийн шинэ загварын J-35 радарт үл үзэгдэх сөнөөгч онгоцыг 2025 оны 9 дүгээр сарын 03-нд болсон Чөлөөлөх дайны 80 жилийн ойн цэргийн ёслолын парадын үеэр анх удаа харуулсан нь уг онгоц Хятадын Тэнгисийн цэргийн нисэх хүчний зэвсэглэлд орсныг баталсан.

Мөн үеэр сөнөөгч онгоцнуудаас гадна олон тооны шинэ загварын нисгэгчгүй нисэх төхөөрөмж танилцуулсны дотор “Үнэнч хамтрагч” нэртэй нисгэгчгүй нисэх төхөөрөмж багтсан нь бие даасан нисэх хүчний салбарын ололт амжилтын илэрхийлэл гэж үзэж болно. Түүнээс гадна цэргийн салбарт ашиглагдах хиймэл оюун ухаанд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлснээр нисгэгчгүй нисэх төхөөрөмжид хүний оролцоог багасгаж маневрын зохицуулалт хийх боломжтой болсон (*Gintz et al., 2026*).

**Тэнгисийн цэргийн хүчин:** Хятадын усан онгоцны үйлдвэрүүд орчин үеийн тэнгисийн цэргийн хөлөг онгоцнуудыг урьд өмнө байгаагүйгээр үйлдвэрлэсэн. Зөвхөн 2025 онд залуурт пуужин устгагчтай 54,000 тонны даацтай шинэ загварын 052D маркийн 7 нэгж дэвшилтэт байлдааны хөлөг онгоцыг Тэнгисийн цэргийн хүчний зэвсэглэлд нэмж оруулсан нь барууны усан онгоцны үйлдвэрлэлийг давсан үзүүлэлт болсон.

Хятад улс 2025 оны 11 дүгээр сард гурав дах хамгийн том нисэх онгоц тээгч Фүжянь хөлөг онгоцыг зэвсэглэлд оруулсан нь АНУ-ын цахилгаан соронзон

түлхэгч системээр (EMALS) тоноглогдсон тээгч хөлөг онгоцтой дүйцэхүйц хэмжээтэй болсон.

АНУ-ын Дайны яамнаас жил бүр гаргадаг ХАЧА-ийн талаарх 2025 оны тайланд, сүүлийн жилүүдэд явагдаж байгаа Бээжингийн цэргийн тэлэлтийг “түүхэн” хэмээн тодорхойлсноос гадна Хятад 2035 он гэхэд 6 нэгж нисэх онгоц тээгч хөлөг онгоц нэмж, нийт 9 нэгж хөлөг онгоцыг АНУ-ын флотын ард байршуулахаар төлөвлөж буйг тэмдэглэсэн байна (*Lariosa 2025*).


**Пуужинт цөмийн цэрэг:** Зэвсэг, техникийн хөгжүүлэлтийн хувьд цөмийн болон ердийн пуужингийн судалгааны чиглэлд түлхүү анхаарал хандуулж, тусгалын нарийвчлал, туршилт болон хөөрөх үйл ажиллагааны явцад доголдол үүсгэхгүй байх тал дээр анхаарч байна.

- Стратегийн байр суурийн хувьд БНХАУ илүү өргөн цар хүрээтэй, илүү олон төрлийн хүчин чадалтай, өндөр цэцтэй тив алгасагч цөмийн бус пуужинг мөн бүтээж эхэлсэн.

- Хятад Улс 2025 оны байдлаар 600 цөмийн цэнэгт хошуутай байгаа ба 2030 он гэхэд энэ тоог 1000-аас илүү, 2035 он гэхэд 1500-д хүргэх төлөвтэй байна.

Түүнээс гадна Бээжин урьдчилан сэрэмжлүүлэх болон хариу цохилт өгөх чадвараа сайжруулснаар, дайсны пуужингийн цэнэгт хошууг дэлбэрэхээс өмнө хариу арга хэмжээ авах боломжтой болоод байна (*Kristensen et al. 2025*).

Үүний зэрэгцээ Бээжин Пуужинт цөмийн цэргийг эрчимтэй өргөжүүлж буйг Пентагоны гаргасан үнэлгээ нотлох ба тухайлбал, Хятадын баруун хэсэгт тив алгасах 300-аас доошгүй баллистик пуужин байрлуулах хүчин чадалтай пуужин хөөргөх гурван шинэ цэг байгуулсан байна.



Эх сурвалж: <https://missilethreat.csis.org/country/china/>

**Кибер орон зайн хүчин:** Хятад улс сансар /кибер/, цахилгаан соронзон орон зайд давамгайлахыг чухалчлан судалгаа хөгжүүлэлтийг эрчимтэй явуулж байна

- “LY-1” нэртэй агаарын довтолгооноос хамгаалах өндөр цэцтэй лазер зэвсгийн системийг бүтээсэн. Цаашид энэ нь дроны сүргийн эсрэг үүрэг гүйцэтгэх боломжтой байхыг үгүйсгэхгүй.

- Дайсны хиймэл дагуулуудыг эсэргүүцэх, сансрын орон зайд удирдлага, харилцаа холбоо, тагнуул, тандалтыг саатуулж, тасалдуулах системийг идэвхтэй хөгжүүлсээр байна.

Хятад улс одоогийн байдлаар 1100 гаруй хиймэл дагуултайгаас 500 гаруйг нь дэвшилтэт мэдрэгчээр тоноглогдсон, далай, агаарын орон зайг хянах зорилгоор байрлуулаад байна. Үүний үр дүнд эдгээр хиймэл дагуулууд Хятад улсыг шинэ мэдээллээр шуурхай хангаснаар, бүс нутагт АНУ болон түүний холбоотнуудад цохилт өгөх нөхцөлийг бүрдүүлж өгсөн гэж үздэг (*U.S. 2025*).

### **Батлан хамгаалах хөгжлийн цаашдын чиг хандлага**

2026 он бол Хятад улсын 2026-2030 хүртэлх 15 дугаар таван жилийн төлөвлөгөөний эхлэлийн жил. 2026 оны 3 дугаар сарын 5-нд эхлэх 14 дэх удаагийн Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Их Хурлын 4 дүгээр чуулганаар жилийн ажлын төлөвлөгөөг батлах бөгөөд үүнд энэ оны батлан хамгаалах төсөв ч мөн багтах аж.

Бээжингийн эрх баригчид, энэ жил инновац, үндэсний аюулгүй байдалд суурилсан өндөр чанартай хөгжил, шинжлэх ухаан технологийн бие даасан байдал, «шинэ чанартай бүтээмж»-д гол анхаарал хандуулах төлөвтэй байна.

Хятад Улсын дарга Ши Жиньпин, 2027 он гэхэд Тайванийг нэгтгэх бэлтгэл ажлыг хангахын тулд Орос-Украины дайны явцыг судалж, байлдааны сургалт бэлтгэлийн төлөвлөлтийг боловсронгуй болгож, цэргийн шинэчлэлийг улам эрчимтэй явуулах төлөвтэй байна. Хятадын арми Тайванийг хүчээр нэгтгэх олон хувилбарт төлөвлөгөөг боловсруулсны дотор десантын ажиллагаа, хүчтэй галын цохилт, далайд бүслэлт хийх зэрэг боломжит ажиллагаанууд байх магадлалтай аж (*Gintz et al., 2026*).

### **ДҮГНЭЛТ**

Хятадын цэргийн шинэчлэл эрчимжихийн хэрээр ухаалаг мэдээлэл болон хиймэл оюунд (AI) суурилсан зэвсэг техник, автомат системүүдийг хөгжүүлэхэд онцгой анхаарч байгаа бөгөөд цаашид ч ухаалагжсан технологид төвлөрөх бодлого баримтлах хандлагатай байна.

Шинэчлэлийн дахин зохион байгуулалтаар Стратегийн дэмжлэгийн хүчнийг татан буулгаж, Мэдээллийн дэмжлэгийн хүчнийг шинээр байгуулснаар орчин үеийн “мэдээлэлжсэн дайн”-д бэлэн байх суурь болсон гэж үзэж болох ч нөгөөтэйгүүр тус улсын технологийн үсрэнгүй хөгжлийг дагаад батлан хамгаалах салбарт хүний нөөцийн бодлогод тавигдах шалгуур өндөр бөгөөд хязгаарлалттай байхыг үгүйсгэхгүй. Энэ нь цэргийн шинэчлэлийн эхний жилээс орон тооны цомхотголыг цэргийн мэргэжлийн онцлогийн эрэлт хэрэгцээнээс хамаарч, мөн технологи суурьтай мэргэжлийн боловсон хүчний томилгоог уян хатан байдлаар оновчтой хэрэгжүүлэх бодлоготой холбоотой юм.

Сүүлийн 5 жилд хятадын батлан хамгаалах төсөв тогтвортой өсөж, үүний тодорхой хэсгийг шинэ технологи, судалгаа, хөгжүүлэлтэд хуваарилж байгааг цэргийн салбарт шинжлэх ухаанч санаачилга, инновац, технологийг ихээхэн дэмжиж буйн илрэл хэмээн үзэж болно. Өндөр технологи болон хиймэл оюунд суурилсан шинэ төрлийн зэвсэглэлүүдийг ашиглаж цэргийн хүчээ тасралтгүй бэхжүүлсээр байна.

Тус улс 2027 онд тохиох ХАЧА-ийн 100 жилээс өмнө “Тайванийг нэгтгэх” зорилгодоо хүрэхийн тулд юуны түрүүнд цэргийн хүчээр авах зорилтыг хэрэгжүүлэхэд гол үүрэг гүйцэтгэх Агаарын болон Тэнгисийн цэрэг, Кибер хүчнээ орчин үеийн дэвшилтэт технологиор бүтээсэн зэвсэглэлээр зузаатгасаар байна.

**Эшлэл авсан сурвалж, судалгааны бүтээл:**

1. Ch, Battulga. 2025. “The Impact of Global Political and Military Developments on National Defense Policies.” *Journal of Security and Defense Studies*, no. 52 (December): 114. <https://doi.org/10.65816/jsds.2025.04.011>.
2. China, ed. 2019. *China’s National Defense in the New Era*. First edition. Foreign Languages Press.
3. Gintz, Alex, Nick Ayrton, Caleb Mills, Nattan Casey Plewissara, Sapna, and Alex Benetos. n.d. *The Asia Outlook: 2026*. <https://www.theasiacable.com/p/the-asia-outlook-2026>.
4. Kristensen, Hans M., Matt Korda, Eliana Johns, and Mackenzie Knight. 2025. “Chinese Nuclear Weapons, 2025.” *Bulletin of the Atomic Scientists* 81 (2): 135–60. <https://doi.org/10.1080/00963402.2025.2467011>.
5. Lariosa, Aaron-Matthew. 2025. *China Wants Nine Aircraft Carriers by 2035, Says New Pentagon Report*. December 24. <https://news.usni.org/2025/12/24/china-wants-nine-aircraft-carriers-by-2035-says-new-pentagon-report>.
6. “Military and Security Developments Involving the People’s Republic of China.” 2025. Department of Defense, USA.
7. U.S., Naval Institute. 2025. *Analysis of China’s 2025 Military Parade and Implications for the U.S. Navy*. <https://www.youtube.com/watch?v=3kqzWhaDyaw&t=193s>.
8. 金久闫. 2024. 由中央军委直接领导指挥. April 21. [https://www.1921.org.cn/jrgz/2024/04/21/detailed\\_2024042138285.html](https://www.1921.org.cn/jrgz/2024/04/21/detailed_2024042138285.html).
9. 雲程萬里通財. 2026. 2026年中国军费预算. Eastmoney.com. January 29. <https://caifuha0.eastmoney.com/>